# НИЙГМИЙН ТУХАЙ МЭДЛЭГ

# 2006

## ХУВИЛБАР А

## НЭГДҮГЭЭР ХЭСЭГ

1. Аль бодомж нь зөв бэ? (1 оноо)
   A. Нийгэмшил нь хүүхэд эхийн хэвлийд олдсон үеэс эхлэл нь тавигддаг
   B. Нийгэмшил нь нярай үеэс эхлэл нь тавигддаг
   C. Нийгэмшил нь хүүхэд хэлд орсноор эхлэл нь тавигддаг
   D. Нийгэмшил нь идэр наснаас эхлэл нь тавигддаг
   E. Нийгэмшил нь ахмад үеэс эхлэл нь тавигддаг
2. Аль нь нийгэмшлийн хүчин зүйлүүдэд шууд хамаарагдахгүй вэ? (1 оноо)
   A. Боловсролын түвшин B. Хэлний мэдлэг
   C. Гэр бүлийн орчин D. Хамт олны хүрээлэл
   E. Нутаг дэвсгэрийн хэмжээ
3. 1990 оноос Монголын нийгмийн харилцаанд эрс шинэчлэлт хийгдэн, хүмүүсийн амьдрах аргад томоохон өөрчлөлт гарч байгаа нь: (1 оноо)
   A. Нийгмийн дэвшил B. Нийгмийн шинэтгэл
   C. Нийгмийн шинэчлэл D. Нийгмийн хувьсал
   E. Нийгмийн хувьсгал
4. Сурагч Бат өндөр нуруутай, хар үстэй бөгөөд сагсан бөмбөг сайн тоглодог. Батын эдгээр шинж нь ямар ойлголтонд хамаарагдах вэ? (1 оноо)
   A. Бие хүн B. Хувь хүн
   C. Суут хүн D. Авьяастай сурагч
   E. Онцгой хүн
5. “Ургийн бичиг” хөтлөхийн гол ач холбогдол нь: (1 оноо)
   A. Хүн өөрийн овог удмаа мэддэг болох B. Бичиг баримт бүрдүүлж, хөтөлж сурах
   C. Нэр хүндээ дээшлүүлэх D. Эд баялаг, өмч хөрөнгөтэй болох
   E. Иргэний үнэмлэх авах
6. Иргэний нийгмийн тухай сонгодог ойлголтыг ямар сэтгэгчид дэвшүүлэн тавьсан бэ? (1 оноо)
   A. Маркс, Энгельс B. И.Кант, Гегель
   C. Аристотель, Платон D. Агваанбалдан, Агваанхайдав
   E. Монтескье, Декарт
7. Сонирхлын бүлэгт хамаарах нь аль вэ? (1 оноо)
   A. Иргэний нийгмийн хэлбэр мөн B. Иргэний нийгмийн хэлбэр биш
   C. Тухайн нөхцөл байдлаас хамаарна D. Дарангуйлагчийн эсрэг хөдөлгөөн
   E. C ба D хариулт
8. Монгол улсын Үндсэн хуулинд “хуулиар ноогдуулсан албан татвар төлөх үүрэгтэй” гэж заасан байдаг нь Монгол улсын иргэний: (2 оноо)
   A. Журамт үүрэг B. Үндсэн үүрэг
   C. Үндсэн эрх D. Иргэний эрх
   E. Ийм заалт байхгүй
9. Аж үйлдвэржсэн ба аж үйлдвэржсэний дараах нийгмийн үндсэн ялгааг олно уу. (2 оноо)
   A. Оршин тогтнож буй цаг хугацаа B. Тухайн нийгмийн хамарсан хүрээ
   C. Хөгжлийн үндэс D. Ноёрхогч нийгмийн бүлэг
   E. Хүн амын тоо, нягтшил
10. Аль бодомж нь зөв бэ? (1 оноо)
    A. Хэм хэмжээ нь улс орон бүрт адил байна
    B. Хэм хэмжээ нь улс орон бүрт өөр өөр байна
    C. Хэм хэмжээ нь улс орон бүрт тогтмол байна
    D. Хэм хэмжээ нь улс орон бүрт давтагдаж байна
    E. Зөв бодомж алга. Дээрх бүгд буруу
11. Монголчууд түүхийн явцдаа уйгуржин, дөрвөлжин бичиг, латин, кирилл зэрэг бичгүүдийг хэрэглэж ирсэн билээ. Энэ нь соёлын ямар шинжид хамаарах вэ? (1 оноо)
    A. Соёлын тогтонгид B. Соёлын өөрчлөлтөнд
    C. Соёлын тогтонги ба өөрчлөлтөнд D. Соёлын өсөлтөнд
    E. Соёлын бууралтанд

12. Хүн амын аль нэг бүлэг даган баримталдаг соёлыг онолын нэрээр хэрхэн тодорхойлдог вэ? (1 оноо)
    A. Явцуу соёл B. Бага соёл C. Ардын соёл
    D. Нийтийн соёл E. Сөрөг соёл
13. П.Пикассогийн “Амьдралын баясгалан” зураг соёлын ямар хэлбэрт хамааргадах вэ? (1 оноо)
    A. Өрнөдийн соёл B. Дорнын соёл C. Элитийн соёл
    D. Ардын соёл E. Нийтийн соёл
14. 1930-аад оны үед 700 гаруй буддын сүм хийдийг нураан сүйтгэсэн нь ямар шалтгаантай вэ? (2 оноо)
    A. Буддын шашин нь нийгэмд сөрөг үр дагавар авчирж байсан учир
    B. Лам нар олноор хар болсон учир
    C. Буддын шашин нь хямралд орсон учир
    D. Буддын шашин нь монголын соёлтой нийцэхгүй байсан учир
    E. Төрөөс шашинг сөрөг соёл гэж үзсэн учир
15. Нийгмийн туршлагыг хуримтлуулж, цааш дамжуулж байдаг нь соёлын ямар үүрэгт хамаарах вэ? (2 оноо)
    A. Харилцааны үүрэг B. Хэм хэмжээ тогтоох үүрэг C. Танин мэдүүлэх үүрэг
    D. Мэдээллийн үүрэг E. Албан ёсны үүрэг
16. Эртний Грек, Ромын үеийн нийгмийн зохион байгуулалтын салбар дахь соёлын ололт юу вэ? (2 оноо)
    A. Театр, риторик, цирк, чимэглэл, баримал туульс
    B. Шинжлэх ухааны үүсэл, хүмүүжлийн тогтолцоо
    C. Олимпийн наадам, он тоолол
    D. Римийн эрх зүй, хот - улс, ардчилсан БНУ
    E. Гүн ухааны сургаал
17. Улс төрийн соёлын тухай ойлголтонд аль нь хамааралтай вэ? (2 оноо)
    A. Улс төрд оролцогчдын биеэ авч явах соёл
    B. Биологи хүчин зүйлүүдийн нэгдэл
    C. Улс төрийн үйл ажиллагаанд оролцогчдын итгэл үнэмшил
    D. Нийтийн соёлын хэмжээ
    E. Нийцтэй улс төрийн оролцоо
18. ................................ гэдэг бол нийгэмд гүйцэтгэх үүргийг нь төрөөс хуулиар тогтоож өгсөн байдаг нийгмийн бүлгүүд юм. (1 оноо)
    A. Боолчлол B. Анги C. Каст
    D. Ялгарал E. Язгуур
19. Америкийн нийгэмд “хөх цамцтангууд” гэж ямар ангийг нэрлэдэг вэ? (1 оноо)
    A. Дээд анги B. Дунд анги C. Ажилчин анги
    D. Доод анги E. Хотод оршин суугчид
20. Нийгмийн давхраажилтын шатаар хүмүүс дээш, доош юм уу хэвтээ чиглэлээр шилжих үйл явцыг хэрхэн тодорхойлдог вэ? (1 оноо)
    A. Нийгмийн ялгарал B. Нийгмийн хөдөлмөрийн хуваарь
    C. Нийгмийн шилжих (мобиль) хөдөлгөөн D. Хүн амын шилжилт
    E. Хүн амын нягтшил
21. Нийгмийн хамгаалал хэнд чиглэгдэж байх ёстой вэ? (1 оноо)
    A. Эмзэг хэсгийнхэнд B. Ажилгүйчүүдэд
    C. Нийгмийн элит хэсгийнхэнд D. Нийгмийн бүх гишүүдэд
    E. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд
22. Нийгмийн даатгалын төрөлд үл хамааргадах зүйл аль нь вэ? (1 оноо)
    A. Ажилгүйдлийн B. Тэтгэврийн
    C. Үйлдвэрийн ослын D. Хөрөнгийн
    E. Эрүүл мэндийн
23. Нийгмийн шилжих хөдөлгөөн босоо ба хэвтээ чиглэлтэй байдаг. Эдгээрийн аль нь нийгмийн хэвтээ чиглэлийн шилжих хөдөлгөөний жишээ вэ? (2 оноо)
    A. Иргэн Болд манаач, сахиул, жижүүр зэрэг ажлуудыг хийж байв.
    B. Компанийн захирал Бат богино хугацаанд дампуурч ядуурав.
    C. Үйлчилгээний ажилтан Чимгээ өөрийн бизнесдээ амжилт олж, улмаар менежер болов.
    D. Малчин Дондог хязгаар нутгаас төвийн бүсэд шилжин суурьшив.
    E. Иргэн Зориг өндөр хөгжилтэй оронд цагаачлав.
24. Социализмийн үеийн Монголын анги давхрааны бүтцийн зөв загварыг олно уу. (2 оноо)
    A. Ажилчин, малчин, сэхээтэн B. Тариачин, албан хаагч, ажилчин
    C. Дарга, ажилчин, малчин D. Албан хаагч, үйлдвэрлэгч, худалдагч
    E. Дээд анги, дунд анги, доод анги

25. Тухайн хүн хүүхэд үрчилж авсаныхаа төлөө нийгмийн халамжаас 49500 төг авсан байна. Үүнийг нийгмийн халамжийн тухай хуулинд хэрхэн тодорхойлсон байдаг вэ? (2 оноо)
   A. Хүүхэд үрчлэн авч өсгөсний тэтгэлэг
   B. Хүүхэд үрчлэн авч өсгөсний тэтгэвэр
   C. Хүүхэд үрчлэн авч өсгөсний тэтгэмж
   D. Хүүхэд асарсны тэтгэлэг
   E. Ийм заалт байхгүй
26. Дараах субьектүүдээс хэн нь нийгмийн асрамжийн үйлчилгээ хүртэх эрхтэй вэ? (2 оноо)
   A. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд
   B. Нэн ядуу өрх
   C. Бие дааж амьдрах чадваргүй, төрөл садангүй өндөр настан
   D. 0-1 насны хүүхдээ асарч буй эх/эцэг
   E. Дээрх бүгд
27. Нийгмийн давхраажилтын үндсэн хэв маягуудыг нэрлэ. (2 оноо)
   A. Боолчлол, каст, язгуур, анги
   B. Төр, улс төрийн нам, сонирхлын бүлэг
   C. Нэр хүнд, эд баялаг, эрх мэдэл, боловсрол
   D. Нэр төр, албан тушаал, ашгийн байдал
   E. Доод анги, дээд анги
28. Пүүсийн (аж ахуйн нэгжийн) гол зорилго юу вэ? (1 оноо)
   A. Эх орноо шаардагдаж буй бүтээгдэхүүнээр хангах
   B. Аж ахуй эрхлэх чадвараараа бусадтай өрсөлдөх
   C. Ажилчдынхаа нийгмийн асуудлыг шийдэх
   D. Хөгжилд хувь нэмрээ оруулах
   E. Ашиг олох
29. Монгол улсын Үндсэн хуульд эдийн засгийн талаар заасан зөв заалтыг тэмдэглэнэ үү. (1 оноо)
   A. Олон хэвшил бүхий эдийн засагтай байна
   B. Төрийн өмч давамгайлсан эдийн засагтай байна
   C. Хувийн өмч давамгайлсан эдийн засагтай байна
   D. Зах зээлийн өрсөлдөөн бүхий эдийн засагтай байна
   E. Төрийн зохицуулалт бүхий эдийн засагтай байна
30. Аль нь макро эдийн засгийн судалгаа вэ? (1 оноо)
   A. Монголын ДНБ-ий өсөлт
   B. Японы зах зээлийн судалгаа
   C. Солонгосын автомашины үнэ
   D. Америкийн жижиг үйлдвэрлэлийн судалгаа
   E. Дээрх бүгд
31. Ардчилсан төрийн эдийн засгийн үүргийг тоочихдоо үл хамаарах зүйл оруулсан бол аль нь вэ? (1 оноо)
   A. Зах зээлийн үйл ажиллагааны эрх зүйн үндсийг бүрдүүлэх
   B. Зах зээлийн үйл ажиллагааны аж ахуйн нэгжүүдийн үнэд нөлөөлөх
   C. Өрсөлдөөнийг хамгаалах
   D. Орлогыг дахин хуваарилах
   E. Эдийн засгийн тогтвортой байдлыг хангах
32. Зах зээлийн үнэ гэдэг нь: (2 оноо)
   A. Эрэлт нь нийлүүлэлтээс бага байх үеийн үнэ
   B. Эрэлт нь нийлүүлэлтээс их байх үеийн үнэ
   C. Эрэлт нь нийлүүлэлттэй тэнцүү байх үеийн үнэ
   D. Худалдан авагч бүтээгдэхүүн үйлчилгээ авсаны төлөө худалдагчид төлж буй мөнгөн төлөөс
   E. Төрийн зүгээс бүтээгдэхүүн үйлчилгээнд тогтоож буй үнэ
33. Хэрвээ А барааны нийлүүлэлт X хэмжээтэй байхад эрэлт нь X+У байвал эдийн засгийн ямар үзэгдэл үүсэх вэ? (2 оноо)
   A. Үйлдвэрлэлийн хэмжээ буурах
   B. Эрэлт буурах
   C. Тэнцвэрт үнэ тогтох
   D. Барааны хомсдол үүсэх
   E. Түүхий эдийн хомсдол үүсэх
34. Аль нь төлбөрийн тухай тодорхойлолт вэ? (2 оноо)
   A. Үйлчилгээ үзүүлсний төлөө төсөвт эсвэл тусгай санд төвлөрүүлж буй мөнгөн хөрөнгө
   B. Тогтоогдсон хувь хэмжээгээр улс орон нутгийн төсөвт оруулж буй мөнгөн хөрөнгө
   C. Өмч ашиглуулсны төлөө төсөвт эсвэл тусгай санд төвлөрүүлж байгаа мөнгөн хөрөнгө

D. Ажилчдын цалин хөлснөөс суутгаж байгаа татвар
E. Дээрх бүгд

35. Хэрвээ ҮНБ - үндэсний нийт бүтээгдэхүүн, ҮЦБ - үндэсний цэвэр бүтээгдэхүүн, ҮО - үндэсний орлого, КЭ - капиталын элэгдэл, ГЦ - гадаад цэвэр гаргалт бол Үндэсний цэвэр бүтээгдэхүүний томьёог ол. (2 оноо)
A. ҮЦБ=ҮНБ+ҮО B. ҮЦБ=ҮО+КЭ
C. ҮЦБ=ҮНБ+ГЦ D. ҮЦБ=ҮНБ-ҮЗ
E. ҮЦБ=ГЦ-ҮНБ

36. АНУ, ХБНГУ, БНСУ зэрэг улс орнуудад иргэдээ гаргаж, үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэх боломжийг төрөөс дэмжиж байгаа бол ажилгүйдлийг бууруулах ямар арга замд хамаарагдах вэ? (2 оноо)
A. Эдийн засгийн арга B. Гадаад хүчин зүйлийг ашиглах арга
C. Улс төрийн арга D. Захиргааны арга
E. Соёлын нөлөөллийн арга

37. Инфляци өсөх хандлагатай байсан ба иргэд дараах үйлдлүүдийг хийсэн гэвэл аль нь илүү оновчтой шийдвэр вэ? (2 оноо)
A. Орон сууцаа худалдсан B. Мөнгөөрөө орон сууц худалдаж авсан
C. Орон сууцаа машинаар сольсон D. Мөнгөө банкинд хадгалуулсан
E. Мөнгөө гэртээ хадгалсан

38. Бодит ҮНБ-ий үзүүлэлт ба нэрлэсэн ҮНБ-ий үзүүлэлтийн хоорондын харьцаа ямар байж болох вэ? (2 оноо)
A. Бодит ҮНБ-ий хэмжээ нь их байна
B. Нэрлэсэн ҮНБ-ий хэмжээ нь их байна
C. Бодит ҮНБ нь нэрлэсэн ҮНБ-тэй тэнцүү үзүүлэлттэй байна
D. Төсвийн хуулиар зохицуулагдана
E. Аль нэг нь их эсвэл бага байж болно

39. Эдийн засгийн тогтолцоог уламжлалт, зах зээлийн, төлөвлөгөөт, холимог гэж ангилан судалж байгаа нь ШУ-ны танин мэдэхүйн ямар аргыг хэрэглэж байна вэ? (2 оноо)
A. Анализ B. Синтез C. Индукци D. Дедукци E. Ажиглалт

40. “Чи миний төлөө юм хийнэ, яагаад гэвэл чи намайг хүндэлдэг” гэж хэлэх нь эрх мэдлийн ямар хэлбэр вэ?
A. Хүч хэрэглэх эрх мэдэл B. Үүрэг үүсгэх эрх мэдэл C. Наймаалцах эрх мэдэл
D. Хүндлүүлэх эрх мэдэл E. Итгүүлэх эрх мэдэл

41. Улс төрийн системийн сонирхлыг нэгтгэх үйл ажиллагааг аль нь голлон гүйцэтгэдэг вэ? (1 оноо)
A. Улс төрийн нам B. Сонирхлын бүлгүүд C. Төр
D. Иргэд E. Дээрх бүгд

42. Ардчиллын бус үнэт зүйлийг нэрлэнэ үү. (1 оноо)
A. Хүний эрх B. Шударга сонгууль C. Эрх мэдлийн төвлөрөл
D. Нээлттэй байдал E. Хуульд захирагдах ёс

43. “Улс төр бол аливаа хувьсгалт намын практик үйл ажиллагааны эхлэх цэг бөгөөд тэрхүү үйлдэл ажиллагааны явц ба эцсийн үр дүнгээр илэрдэг.” гэсэн тодорхойлолтыг дүгнэж үзвэл ямар шинж чанарыг агуулсан байна вэ? (2 оноо)
A. Улс төрийг ёс зүйн үүднээс тодорхойлсон
B. Улс төрийг практик талаас нь тодорхойлсон
C. Улс төрийг зүүний үзэл баримтлалын өнцгөөс тодорхойлсон
D. Улс төрийг барууны үзэл баримтлалын талаас тодорхойлсон
E. Улс төрийг институтийн онолоор тодорхойлсон

44. Засгийн газрын ...-р тогтоолыг ҮЭ-ээс эсэргүүцэж шаардлага тавьсны дагуу Засгийн газрын зүгээс уг тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулжээ. Энэ үйл явц нь улс төрийн системийн аль бүтцэд хамаарах вэ? (2 оноо)
A. Улс төрийн системийн эргэх холбоо B. Улс төрийн системийн оролт
C. Улс төрийн системийн гаралт D. Улс төрийн системийн орчин
E. Дээрх хариултуудын аль нь ч биш

45. Эх сурвалж. Луков - Данненбергийн иргэдийн санаачилсан ухуулах хуудас. Германд атомын аж үйлдвэрийн байгууламжийн эсрэг, ерөөс нутгаа хэт барилгажуулахын эсрэг шууд хүч хэрэглэхгүй суулт хийх, хэвтэж хаалт болох зэргээр эсэргүүцэл гардаг. Энэ бүхэн нь бүх хүний амьдралын төлөө учир цагдаагийн оролцоо хэрэггүй... Парламентын олонхи ч энэ хариуцлагыг бидэнд олгоогүй юм. Бидний энэ арга хэмжээ бол Үндсэн хуулиар олгогдсон эсэргүүцэх эрхээ л ашиглаж байгаа хэрэг мөн. Дээрх эх сурвалж нь улс төрийн системийн аль бүрэлдэхүүн хэсгийн тухай өгүүлж байна вэ? (2 оноо)
A. Улс төрийн системийн орчин B. Улс төрийн системийн оролт
C. Улс төрийн системийн гаралт D. Улс төрийн системийн эргэх холбоо
E. Улс төрийн системийн шийдвэр

46. Хэрвээ улс төрийн нам байгаль орчныг хамгаалах талаарх төрийн бодлогыг эсэргүүцсэн иргэдийн хөдөлгөөнийг дэмжиж байвал энэ нь ямар төрлийн улс төрийн нам бэ? (2 оноо)
   A. Консерватив нам   B. Ардчилсан нам   C. Зүүн төвийн нам
   D. Либерал нам   E. Аль нь ч байж болно
47. Хэсэг аж ахуй эрхлэгчид татварын шинэ хуулийг эсэргүүцэж нэг удаагийн жагсаал хийжээ. Эдгээр хүмүүс нь сонирхлын бүлгийн аль хэв шинжид хамаарах вэ? (2 оноо)
   A. Холбооны шинжтэй   B. Бүрдлийн шинжтэй   C. Холбооны бус шинжтэй
   D. Тодорхойгүй төлөвтэй   E. Нийгмийн шинжтэй
48. Ардчиллын сонгодог онол ба олон ургальч ардчиллын онолууд нь ямар асуудлаар хоорондоо өөр байр суурьтай байдаг вэ? (2 оноо)
   A. Ардчилсан засаглал нь хэнээс эхтэй байх вэ гэсэн асуудлаар
   B. Төр засаг нь хэний өмнө хариуцлага хүлээх вэ гэсэн асуудлаар
   C. Сонгуулийн ямар системийг хэрэглэх асуудлаар
   D. Улс төрийн ямар нам ноёрхох ёстой вэ гэсэн асуудлаар
   E. Тийм асуудал байхгүй
49. 1990 онд Монгол улсад ардчилсан хувьсгал гарахад аль хүчин зүйл нөлөөлсөн бэ? (2 оноо)
   A. Нэг намын тогтолцоо
   B. Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн үр ашиггүй байдал
   C. Үзэл суртлын дарангуйлал
   D. Зөвлөлт социалист бүгд найрамдах холбоот улсын задрал
   E. Дээрх бүх хүчин зүйлс нөлөөлсөн
50. Хэрвээ иргэдийн олонхи нь “хүмүүс үзэл бодлоороо хуваагдах нь нийгэмд эмх замбараагүй байдал бий болгох аюултай” гэж үзэж байвал: (2 оноо)
   A. Улс төрийн соёл төлөвшсөний шинж   B. Ардчилсан бус улсын шинж
   C. Ардчилсан үнэт зүйлс төлөвшөөгүйн шинж   D. Сөрөг соёл давамгайлсаны шинж
   E. B ба D хувилбар
51. Олон улсын харилцааны хүмүүнлэгийн салбарт хамааргдахгүй чиглэлийг дурьдсан бол аль нь вэ? (1 оноо)
   A. Эмэгтэйчүүд, хүүхдийн эрхийг хамгаалах
   B. Химийн болон бактерологийн зэвсэг дэлгэрүүлэхгүй байх
   C. Ядуурал, гуйланчлал, өлсгөлөнг арилгах
   D. Хүний эрхийг хамгаалах
   E. Бүгд хамааргдана
52. Монгол улсын гадаад харилцааны олон тулгуурт зарчим гэдэг нь: (1 оноо)
   A. Идэвхитэй гадаад бодлого явуулах
   B. Тэнцвэртэй гадаад бодлого явуулах
   C. Үндэсний эрх ашигт нийцсэн бодлого явуулах
   D. Тооны олон, хэлбэрийн олон харилцаа явуулах
   E. Тооны олон, хэлбэрийн цөөн харилцаа явуулах
53. Ямар улсын санаачлагаар Монголд хандивлагч улсуудын зөвлөлгөөн анх зохион байгуулагдсан бэ? (1 оноо)
   A. Герман   B. Япон   C. БНСУ   D. АНУ   E. Монгол
54. НҮБ-ын төрөлжсөн байгууллагад орохгүй байгууллагыг олно уу. (2 оноо)
   A. Олон улсын валютын сан   B. Дэлхийн эрүүл мэндийн байгууллага
   C. Дэлхийн оюуны өмчийн байгууллага   D. Олон улсын шүүх
   E. Дэлхийн цаг уурын байгууллага
55. Эвсэлд үл нэгдэх зарчмыг мөрдөх нь ямар ач холбогдолтой вэ? (2 оноо)
   A. Даяаршлийн сөрөг нөлөөллөөс сэргийлэх
   B. Улс орондоо гадны цэрэг оруулахгүй байх
   C. Үүрэг хариуцлага хүлээхгүй байх
   D. Бусдаас ялгарахгүй байх
   E. Дайны аюулаас сэргийлэх
56. Яагаад 1955 онд Варшавын гэрээний орнуудын байгууллага хэмээх эвсэл байгуулагдсан бэ? (2 оноо)
   A. Социалист орнуудын гадаад бодлогыг төвлөрүүлэх үүднээс
   B. Дэлхий дээр олон туйлт харилцаа тогтоохын тулд
   C. НАТО-ийн эсрэг сөрөн зогсохын тулд
   D. НАТО-тай хамтран ажиллахын тулд
   E. Дэлхийд энх тайван тогтоохын тулд

57. УИХ-аас соёрхон баталсан Олон улсын конвенци нь дотоодын хууль тогтоомжтой зөрчилдөж байгаа бол: (2 оноо)
   A. Уг конвенци хүчингүй болно
   B. Уг конвенцийг дотоодын хууль тогтоомжид тохируулан өөрчилнө
   C. Үндсэн хуулийн цэцээр хэлэлцэгдэнэ
   D. УИХ-аар дахин хэлэлцэнэ
   E. Дотоодын хууль тогтоомжийг уг конвенцид нийцүүлэн өөрчилнө
58. Монгол улсын элсэн ороогүй Олон улсын байгууллагыг олно уу. (2 оноо)
   A. Европын сэргээн босголт, хөгжлийн банк
   B. Азийн хамтран ажиллах, итгэлцлийг бэхжүүлэх асуудлаарх зөвөлгөөн
   C. Азийн хөгжлийн банк
   D. Дэлхийн худалдааны байгууллага
   E. Тийм хариулт алга

## ХОЁРДУГААР ХЭСЭГ

2.1. Дараах ойлголтуудыг зөв холбоно уу. (5 оноо)
   A. Нийгэмд хамаарахуйц эерэг үр дагаврууд
   B. Нийгмийн хуучин байгуулал шинэ байгуулалд эрс шилжилт хийх үйл явц
   C. Нийгэмд хэсэгчилсэн болон аажим хувьсал хийх
   D. Нийгмийн амьдралын бүх хүрээг хамарсан иж бүрэн суурь өөрчлөлт
   E. Нийгэм дэх зохицуулагч хэм хэмжээ, зан заншлуудын цогц

   1. Соёл 2. Хувьсгал 3. Шинэтгэл 4. Дэвшил 5. Шинэчлэл

2.2. Доорх үзэл баримтлалууд аль намд харьяалагдах болохыг зөв холбоно уу. (5 оноо)
   A. Хувийн өмчийг хураах төрийн өмч болгоно
   B. Улс орны бодлогын гол цөм нь үндсэрхэг үзэл байна
   C. Эдийн засагт төрийн оролцоо хязгаарлагдмал байна
   D. Эдийн засагт төрийн оролцоо давамгайлах чиглэлийг баримтална
   E. Хувийн өмчтөний үйлдвэрлэсэн нийгмийн баялгийн хуваарилалтанд төрөөс хяналт тавина

   1. Фашист 2. Социалист 3. Коммунист 4. Социал демократ 5. Либерал

## ХУВИЛБАР B

## НЭГДҮГЭЭР ХЭСЭГ

1. Соёл хэмээх ойлголтонд багтах элемент аль нь вэ? (1 оноо)
   A. Байгууллага B. Дээдсийн соёл C. Харилцаа
   D. Нийтийн соёл E. Ардын соёл
2. Аль бодомж нь зөв бэ? (1 оноо)
   A. Ардын зан заншил нь зөв буруу гэж хатуу үнэлэгдэхгүй
   B. Ардын зан заншил нь зөв буруу гэж үнэлэгдэнэ
   C. Ардын зан заншил нь албан хэм хэмжээ бөгөөд зөв буруу гэж нэлэгдэнэ
   D. Ардын зан заншил нь албан хэм хэмжээ бөгөөд зөв буруу гэж үнэлэгдэхгүй
   E. Бүгд буруу бодомж
3. Иргэн Готов өглөө эрт босож биеийн тамирын дасгал тогтмол хийдэг. Уг үйлдлийг онолын нэрээр юу гэх вэ?
   A. Заншил B. Уламжлал C. Зуршил
   D. Авьяас E. Нийтийн соёл
4. Шашин шүтлэгийн танин мэдэхүйн гол үндэс нь юу байдаг вэ? (1 оноо)
   A. Итгэл бишрэл B. Таамаглал, дүгнэлт C. Сэтгэж танин мэдэх
   D. Онол практик E. B ба C хувилбар
5. Монголчууд “Цаг цагаараа байдаггүй, Цахилдаг хөхөөрөө байдаггүй” хэмээн хэлэлцдэг. Энэ нь ямар соёлын илрэл вэ? (1 оноо)
   A. Нийтийн соёл B. Уламжлал, зан заншил C. Ёс суртахуун, түүх
   D. Элитийн соёл E. Ардын соёл

6. Зарим оронд сайн гэж үнэлэгддэг зүйл яагаад зарим оронд эсрэгээр үнэлэгдэж болдог вэ? (2 оноо)
   A. Хэлний ялгаа
   B. Газар зүйн байрлалын ялгаа
   C. Хүн амын тоо, нягтшилийн ялгаа
   D. Боловсролын тогтолцооны ялгаа
   E. Уламжлал, зан заншлын ялгаа
7. Үндэстэн хооронд шашны үзлүүдийн сөргөлдөөнөөс шалтгаалан иргэний мөргөлдөөн тэмцлүүд гарч байгаа бол энэ нь: (2 оноо)
   A. Гэмт хэрэг, гэмт явдал
   B. Соёлын зохицуулалтын хомсдол
   C. Соёлын хөгжилт
   D. Ёс суртахууны доройтол
   E. Газар нутгийн төлөө тэмцэл
8. Зурагт, интернет, компьютерийн дэлгэцээр зэрлэг балмад үйлдэл бүхий кино, мэдээллийг хэт их хүлээж авах нь сэтгэхүйн ямар гажигт хүргэж болох вэ? (2 оноо)
   A. Өөрийгөө үгүйсгэх
   B. Бусдаас суралцах
   C. Мэдрэмжгүй болох
   D. Манлайлагч болох
   E. Бусдыг үгүйсгэх
9. Аль нь нийгэмшлийн илүү чухал хүчин зүйл вэ? (1 оноо)
   A. Байгаль, газар зүйн орчин
   B. Гэр бүлийн орчин
   C. Хэвлэл мэдээлэл
   D. A ба C хариулт
   E. Хиллэж буй улсууд
10. Хүн төрөлхтний мэдлэг анх үүсэхдээ аль шинж нь давамгай байсан бэ? (1 оноо)
    A. Нэгдмэл шинж
    B. Хосолмол шинж
    C. Олон төрлийн
    D. Гурван төрлийн
    E. Аль нь ч биш
11. Хүмүүсийг нийгэмшүүлэх ба суурь үнэт зүйл, дадлага практикт суралцуулах үндсэн үүргийг гүйцэтгэгч нь хэн бэ? (1 оноо)
    A. Багш, сурган хүмүүжүүлэгч
    B. Эцэг эх
    C. Ажил олгогч
    D. Хууль тогтоогч
    E. Лам, санваартан
12. Нийгмийг хамгийн ерөнхий утгаар нь хэрхэн ангилдаг вэ? (1 оноо)
    A. Улс орон ба төр
    B. Соёл ба иргэншил
    C. Хосолмол ба нийлмэл
    D. Энгийн ба нийлмэл
    E. Энгийн ба хосолмол
13. Улс төрийн нам аль нь вэ? (1 оноо)
    A. Иргэний нийгмийн хэлбэр мөн
    B. Иргэний нийгмийн хэлбэр биш
    C. Тухайн нөхцөл байдлаас хамаарна
    D. Дарангуйлагчийн эсрэг хөдөлгөөн
    E. C ба D хариулт
14. Донров үйлдвэрт ажилладаг бөгөөд үйлдвэрийн тэргүүний ажилчдын нэг юм. Донровын эдгээр шинж нь ямар ойлголтонд хамаарагдах вэ? (1 оноо)
    A. Бие хүн
    B. Хувь хүн
    C. Суут хүн
    D. Чинээлэг хүн
    E. Онцгой хүн
15. Буруу хамаарлыг олно уу. (2 оноо)
    A. Эдийн засаг - хэрэгцээ ба нөөц
    B. Улс төр - хязгаарлагдмал нөөц
    C. Давхраажилт - тэгш бус байдал
    D. Соёл - үнэт зүйлс, үнэлэмж
    E. Даяаршил - Олон улсын харилцаа
16. Монгол улсын Үндсэн хуулинд “... байгаль орчноо хамгаалах үүрэгтэй.” гэж заасан байдаг нь Монгол улсын иргэний мөн. (2 оноо)
    A. Журамт үүрэг
    B. Үндсэн үүрэг
    C. Үндсэн эрх
    D. Иргэний эрх
    E. Ийм заалт байхгүй
17. Нийтээрээ юм уу олонхи даган баримталдаг хэм хэмжээнээс аль нэг тийш хэлбийсэн авир үйлдлийг социлогид юу гэж нэрлэдэг вэ? (2 оноо)
    A. Гаж үзэгдэл
    B. Гоц үзэгдэл
    C. Гэмт хэрэг
    D. Этгээд авир үйлдэл
    E. Онцгой авир үйлдэл
18. Иргэн Дорж өнөө үед газар тариалан эрхэлж, ан агнаж амьдарч байгаа бол аль нийгэмд харьяалагдаж байна вэ? (2 оноо)
    A. Агнуурын болон түүвэрлэгчдийн нийгэм
    B. Цэцэрлэгийн аж ахуй буюу энгийн тариалангийн нийгэм

C. Газар тариалангийн нийгэм
D. Аж үйлдвэржсэн нийгэм
E. Аж үйлдвэржсэний дараах нийгэм

19. Монгол банкны үйл ажиллагааны чиглэлд аль нь хамаарагдахгүй вэ? (1 оноо)
A. Мөнгөн хадгаламж хүлээж авах
B. Мөнгөн зээл олгох
C. Мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх
D. Валютийн ханшийг тогтворжуулах
E. А ба В хариулт

20. Аль нь микро эдийн засгийн судалгаа вэ? (1 оноо)
A. Монголын дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлт
B. Японы үндэсний нийт бүтээгдэхүүний үзүүлэлт
C. Солонгосын автомашины зах зээлийн үнэ
D Америкийн гадаад хөрөнгө оруулалтын бодлого
E Дээрх бүгд

21. Эдийн засгийн ямарч тогтолцооны үед байнга тулгарч байдаг мөнхийн асуудал юу вэ? (2 оноо)
A. Эдийн засгийн өсөлт
B. Мөнгөний ханш
C. Хязгаарлагдмал нөөц
D. Ажилгүйдэл
E. Татвар

22. Өрсөлдөөн шударга явагдаж байгааг аль нь илэрхийлэхгүй байна вэ? (2 оноо)
A. Бүтээмж дээшилнэ
B. Зардал буурна
C. Ашиг нэмэгдэнэ
D. Үнэ өснө
E. Чанар сайжирна

23. Хэрвээ монголын зах зээлд америк долларын ханш өсөж байвал доорхи хүчин зүйлсийн аль нь нөлөөлсөн гэж үзэх вэ? (2 оноо)
A. АНУ-д эдийн засгийн хямрал болсон
B. Монгол Банкнаас их хэмжээний валют гүйлгээнд оруулсан
C. Шатахууны хомсдолд орсон
D. Банкны хүү өссөн
E. Төгрөгийн худалдан авах чадвар буурсан

24. Бүтээгдэхүүний үнэ буурахад эрэлт нэмэгдэх зүй тогтол байдаг. Гэтэл костюмны үнийг хичнээн бууруулсан ч түүнийг худалдан авах байдал нэмэгдсэнгүй гэвэл үүнийг эдийн засагт юу гэж тодорхойлдог вэ? (2 оноо)
A. Дээд зэргийн ашигт чанар буурах үзэгдэл
B. Дээд зэргийн ашигт чанар өсөх үзэгдэл
C. Эрэлтийн хэмжээ буурах үзэгдэл
D. Эрэлтийн хэмжээ тэнцвэртэй байх үзэгдэл
E. Нийлүүлэлтийн хэмжээ нэмэгдэх үзэгдэл

25. А барааны нийлүүлэлт Х хэмжээтэй байхад эрэлт нь Х - У байвал эдийн засгийн ямар үзэгдэл үүсэх вэ? (2 оноо)
A. Үйлдвэрлэлийн хэмжээ нэмэгдэнэ
B. Эрэлт буурна
C. Тэнцвэрт үнэ тогтоно
D. Барааны илүүдэл бий болно
E. түүхий эдийн хомсдол бий болно

26. Хэрвээ ҮНБ - үндэсний нийт бүтээгдэхүүн, ҮЦБ - үндэсний цэвэр бүтээгдэхүүн, ҮО - үндэсний орлого, ШБТ - шууд бус татвар бол Үндэсний орлогын томьёог ол. (2 оноо)
A. ҮО=ҮНБ - ҮЦБ
B. ҮО=ҮЦБ - ШБТ
C. ҮО=ҮЦБ + ШБТ
D. ҮО=ҮНБ + ҮЦБ
E. ҮО=ҮНБ - ШБТ

27. Аль нь хураамжийн тухай тодорхойлолт вэ? (2 оноо)
A. Үйлчилгээ үзүүлсний төлөө төсөвт эсвэл тусгай санд төвлөрүүлж буй мөнгөн хөрөнгө
B. Тогтоогдсон хувь хэмжээгээр улс орон нутгийн төсөвт оруулж буй мөнгөн хөрөнгө
C. Өмч ашиглуулсны төлөө төсөвт эсвэл тусгай санд төвлөрүүлж байгаа мөнгөн хөрөнгө
D. Ажилчдын цалин хөлснөөс суутгаж байгаа татвар
E. Дээрх бүгд

28. Хязгаар нутгуудаас шилжин ирэгсдийн тоог хязгаарлах замаар Засгийн газар ажилгүйдэлтэй тэмцэж байгаа бол энэ нь ажилгүйдлийг бууруулах ямар арга замыг хэрэглэж байна вэ? (2 оноо)
A. Эдийн засгийн арга
B. Гадаад хүчин зүйлийг ашиглах арга
C. Улс төрийн арга
D. Захиргааны арга
E. А ба С хариулт

29. Зах зээлийн механизмд "өршөөл" гэж байхгүй. Энд ихээхэн өмч хөрөнгө, капитал, газар эсвэл оюуны боловсрол өндөртэй хүмүүс их ашиг хүртэж, бусдад нь бага хувь оногдох магадлалтай. Мөн нийгэмд эмзэг бүлгийнхэн оршсоор байдаг. Энэ тохиолдолд төр эдийн засагт ямар зохицуулалт хийх ёстой вэ? (2 оноо)

A. Эрх зүйн үндсийг бүрдүүлэх
B. Өрсөлдөөнийг хамгаалах
C. Орлогыг дахин хуваарилах
D. Эдийн засгийг тогтворжуулах
E. Эдийн засгийг хямралаас гаргах

30. Хэрвээ иргэн Дорж хангалттай хөрөнгөтэй, гадаад хэл, компьютерийн өргөн мэдлэгтэйгээр өөрийн бизнесийг эхэлсэн болович алдагдалд орсон бол энэ нь ямар хүчин зүйлийн дутагдлаас болсон бэ? (2 оноо)
A. Капитал
B. Газар
C. Бизнесийн хамтрагч
D. Төрийн дэмжлэг
E. Үйлдвэрлэл эрхлэх чадвар

31. Баяраа хөдөлмөрийн биржид бүртгүүлэн ажил хайж байгаа болович түүнд таарч тохирох ажил олдохгүй байсаар 2 жил болж байна. Баяраа нийгмийн аль бүлэгт хамаарагдах вэ? (1 оноо)
A. Хязгаар нутгийнханд
B. Бизнес эрхлэгчид
C. Эмзэг бүлгийнхэнд
D. Баяраад ажил олдоно
E. Доод анги

32. Америкийн нийгэмд “цагаан цамцтангууд” гэж ямар ангийг нэрлэдэг вэ? (1 оноо)
A. Дээд анги
B. Дунд анги
C. Дээдийн доод анги
D. Ажилчин анги
E. Доод анги

33. Монголд боолчлолын ямар хэлбэр илүү түгээмэл шинжтэй оршиж байсан бэ? (1 оноо)
A. Сонгодог хэлбэр
B. Эртний хэлбэр
C. Гэрийн боол
D. Боолчлох ёс байгаагүй
E. A ба B хариулт

34. Улс орны үйлдвэржилтийн шинэчлэгдэх явцыг даган өөрчлөгдөх хөдөлгөөн нь ямар төрлийн шилжилт вэ?
A. Газар зүйн шилжилт хөдөлгөөн
B. Хэвтээ чиглэлийн хөдөлгөөн
C. Босоо чиглэлийн хөдөлгөөн
D. Бүтцийн шилжилт хөдөлгөөн
E. Аль нь ч биш

35. Нийгмийн халамжийн төрөлд хамаарахгүй зүйлийг тэмдэглэнэ үү. (1 оноо)
A. Халамжийн тэтгэвэр
B. Халамжийн тэтгэмж
C. Халамжийн даатгал
D. Халамжийн үйлчилгээ
E. Асрамжийн үйлчилгээ

36. ........................ гэдэг бол хувь хүн юм уу гэр бүл хүнс, хувцас, сууцтай байхад хүрэлцэх доод орлого гэж албан ёсоор тогтоосон мөнгөний хэмжээ юм. (1 оноо)
A. Ядуурлын доод жишиг
B. Ядуурлын түвшин
C. Ядуурлын коэффициент
D. Ядуурлын босго
E. Ядуурлын дээд жишиг

37. Орчин үед нийгмийн давхраажилтын үндсэн хэмжигдэхүүнд ямар шалгууруудыг оруулж байна вэ? (2 оноо)
A. Каст, боолчлол, язгуур, анги
B. Нэр хүнд, эд баялаг, эрх мэдэл, боловсрол
C. Нэр төр, албан тушаал, ашиг орлого
D. Дээд анги, доод анги
E. Эрх зүй, ёс суртхуун

38. Дорж дунд сургуулиа амжилттай төгсөөд хуулийн мэргэжил эзэмшин Олон улсын шүүхийн байгууллагад амжилттай ажиллаж байгаа бол ямар чиглэлийн шилжих хөдөлгөөнд хамаарагдах вэ? (2 оноо)
A. Хэвтээ чиглэлийн
B. Боловсролын чиглэлийн
C. Босоо чиглэлийн
D. Хөндлөн чиглэлийн
E. Газарзүйн шилжилт

39. Хэрвээ Бат нийгмийн даатгалаас тэтгэвэр авах эрх үүргийн харилцаанд ороогүй болович сар бүр 15000 төгрөгийг нийгмийн халамжийн сангаас авч байгаа бол үүнийг ................. гэнэ. (2 оноо)
A. Нийгмийн халамжийн тэтгэмж
B. Нийгмийн халамжийн тэтгэвэр
C. Нийгмийн халамжийн даатгал
D. Нийгмийн асрамжийн даатгал
E. Эдгээрээс өөр

40. Иргэн Баатар 65 настай, өндөр насны тэтгэвэр авах эрх үүсээгүй, төрөл садангүй, өөрийн гэсэн жижиг гэртэй бол: (2 оноо)
A. Тэрээр өндөр насны тэтгэвэр авах ёстой
B. Тэрээр нийгмийн халамжийн тэтгэвэр авах эрхтэй
C. Тэрээр сар бүр төрөөс 10 000 төгрөг авах эрхтэй
D. Тэрээр нийгмийн халамжийн тэтгэвэр авах эрхгүй
E. C ба Dхувилбар

41. НҮБ-ын өдөр тутмын үйл ажиллагааг аль нь удирдан явуулдаг вэ? (1 оноо)
A. Аюулгүйн зөвлөл
B. Ерөнхий ассамблей

C. Нарийн бичгийн дарга нарын газар
D. Эдийн засаг, нийгмийн зөвлөл
E. Олон улсын шүүх

42. 1990 оноос өмнөх НАТО-ын үүргийг одоогийнхтой нь харьцуулбал ямар ялгаатай вэ? (1 оноо)
A. Үүрэг, хариуцлага нь багассан
B. Харьцуулах боломжгүй
C. Илүү өргөн үүрэгтэй болсон
D. Ямар ч ялгаагүй
E. Европын Холбоог хамгаалах үүрэгтэй болсон

43. Идэвхитэй гадаад бодлогын зарчим гэдэг нь: (1 оноо)
A. Аль болох олон улстай харилцах
B. Олон талт хамтын ажиллагааны нөөц бололцоог бүрэн дүүрэн дайчлах
C. Үндэсний язгуур эрх ашиг сонирхлыг сахин хамгаалах
D. Стратегийн зорилтыг шатлан хэрэгжүүлэх
E. Дээрх бүгд

44. НҮБ-ын гол байгууллагад орохгүй байгууллагыг олно уу. (2 оноо)
A. Аюулгүйн зөвлөл
B. Олон улсын валютийн сан
C. Асрамжийн зөвлөл
D. Олон Улсын шүүх
E. Нарийн бичгийн дарга нарын газар

45. НҮБ-ын зорилгод нийцэхгүй үйл ажиллагаа аль нь вэ? (2 оноо)
A. Дэлхийн дулаарлын үр дагаврыг арилгах
B. Цагаан будааны шинэ сорт бий болгох
C. Дэлхийн эдийн засгийн нөхцөл байдпын тухай хурал зохион байгуулах
D. Монгол улсад хөгжлийн тусламж үзүүлэх
E. Олон улсын бирж дээр бонд гаргах

46. Монгол улсын санаачилгаар эхэлсэн НҮБ-ын 10 жилийн хөтөлбөрийг олно уу. (2 оноо)
A. Бүх нийтээрээ бичигтэн болох
B. Цөмийн зэвсгийг устгах
C. Монгол улс дахь дэлхийн соёлын өвийг сэргээх
D. Терроризмтэй тэмцэх
E. Орон гэргүй, асран хамгаалагчгүй хүүхдүүдэд туслах

47. Монгол улсын элсэн орсон Олон улсын байгууллагыг олно уу. (2 оноо)
A. Европын сэргээн босголт, хөгжлийн банк
B. НАТО
C. Европын холбоо
D. Шанхайн хамтын ажиллагааны байгууллага
E. Тийм хариулт алга

48. “Чи миний хүссэн юмыг хий тэгэхгүй бол...”, “Миний хүссэнийг хий оронд нь би чиний хүссэнийг хийе”, “Чи миний төлөө юм хийнэ, яагаад гэвэл чи намайг хүндэлдэг” гэсэн бодомжууд нь юуг илэрхийлж байна вэ? (1 оноо)
A. Дагуулах эрх мэдэл
B. Дагуулах соёл
C. Хүссэнээ хийлгэх чадамж
D. Хэрэгжүүлэх эрх мэдлийн төрлүүд
E. Эрх мэдлийг хэрэгжүүлэх хэлбэрүүд

49. Улс төрийн системийн сонирхлыг хэрэгжүүлэх үйл ажиллагааг аль нь голлон гүйцэтгэдэг вэ? (1 оноо)
A. Улс төрийн нам
B. Сонирхлын бүлгүүд
C. Төр
D. Иргэд
E. Дээрх бүгд

50. Хэрвээ энэхүү бүлэг өөрсдийн эрх ашигт нийцсэн хууль гаргуулахаар парламентын гишүүдэд шууд нөлөө үзүүлж байгаа бол улс төрийн ямар томьёололд багтах вэ? (1 оноо)
A. Сонирхлын бүлэг
B. Намын бүлэг
C. Засгийн газар
D. Нөлөөллийн бүлэг
E. Шахалтын бүлэг

51. Ардчилсан сонгуулийн үндсэн зарчимд хамаарахгүй зүйл дурдсан бол аль нь вэ? (1 оноо)
A. Бүх нийтийн
B. Чөлөөтэй
C. Олон нийтийн
D. Тэгш эрхтэй
E. Нууц

52. Аль нь улс төрийг тодорхойлсон марксист онолын тодорхойлолт вэ? (2 оноо)
A. Улс төр гэдэг бол эрх мэдэлд хүрэх, эрх мэдлийг тогтоон барьж байх ба ашиг хонжоо олохын тулд эрх мэдлийг ашиглах албадлагын хэрэгслийн цогц мөн
B. Улс төр гэдэг бол нийгмийн амьдралын хөгжил хөдөлгөөн, төрийн үйл ажиллагааны урлаг, түүний хуульчлагдсан зорилго мөн
C. Улс төр бол зүй зохистой дэг журмын төлөө хийх тэмцэл мөн
D. Улс төр гэдэг бол өөрсдийн нийгэм, эдийн засгийн өвөрмөц ашиг сонирхол болон зорилгоо хэрэгжүүлэхийн төлөө дэлхийн систем ба улс гүрэн, анги ба тэдний намаас явуулж байгаа тэмцэл нэвт шингэсэн нийгмийн амьдралын хүрээ мөн
E. Улс төр бол нийгмийн үйл ажиллагаа .............................. түүний хэрхэн хуульчлагдсан байдал, (мөн бөгөөд) нийгмийн сөргөлдөөнийг заавал зохицуулдаг ач холбогдолтой

53. Иргэдээс гаргасан саналын дагуу парламент шинэ хуулийн төсөл баталсан нь сонгогч олны дэмжлэгийг хүлээж чаджээ. Энэ үйл явц нь улс төрийн системийн аль бүтцэд хамаарах вэ? (2 оноо)
    A. Улс төрийн системийн орчин
    B. Улс төрийн системийн оролт
    C. Улс төрийн системийн гаралт
    D. Улс төрийн системийн эргэх холбоо
    E. Дээрх хариултуудын аль нь ч биш
54. "Иргэний хөдөлгөөнийхөн тэмцлээ хөдөө рүү чиглүүлж эхэллээ. ... Өнөөдөр Сүхбаатар аймагт Төмөртэйн цайрын ордын баялгийг өмнө хөрш рүү гаргаж байгааг эсэргүүцсэн тэмцэл орон нутгийн иргэдийн дунд өрнөөд байгаа аж. Мөн Дархан-Уул аймгийн төвд иргэд төрийн ажилтнуудын авилга, газар хувьчлалын хуйвалдааныг эсэргүүцэн жагсаж цуглаад байгаа гэнэ... *Эх сурвалж. Өдрийн сонин, 2006 он №110"*
    Дээрх эх сурвалж нь улс төрийн системийн аль бүрэлдэхүүн хэсгийн тухай өгүүлж байна вэ? (2 оноо)
    A. Улс төрийн системийн орчин
    B. Улс төрийн системийн эргэх холбоо
    C. Улс төрийн системийн гаралт
    D. Улс төрийн системийн оролт
    E. Улс төрийн системийн шийдвэр
55. Хэрвээ тухайн оронд Консерватив нам оршин байвал энэ нь ямар төрийн тогтолцоотой улс вэ? (2 оноо)
    A. Их Британий хатан хааны захиргаанд байдаг
    B. Хуучинсаг үзэлтнүүд ноёрхсон төртэй
    C. Холбооны улс
    D. Нэгдмэл улс
    E. Аль нь ч байж болно
56. Үндсэн хуулинд "... засгийн бүх эрх мэдэл ард түмний гарт байна." гэж заасан бол энэ нь ардчиллын ямар онолтой зөрчилдөж байна вэ? (2 оноо)
    A. Сонгодог ардчиллын онол
    B. Олон ургальч ардчиллын онол
    C. Ардчиллын элитийн онол
    D. Ардчилсан засаглалын онол
    E. Цөөнхийн ардчиллын онол
57. Хэрвээ сонгуулийн нэг тойрог 6000 сонгогчтой, нөгөө тойрог нь 10 000 сонгогчтой бөгөөд тойрог бүр дээр нэр дэвшигчдээс нэг л хүнийг мажоритар системээр сонгох бол ардчилсан сонгуулийн зарчимд нийцэхгүй зүйлийг олно уу. (2 оноо)
    A. Хүний сонгох сонгогдох эрх хязгаарлагдсан байна
    B. Сонгуулийн систем нь шударга бус
    C. Сонгууль бүх нийтийг хамарч чадахгүй
    D. Ардчилсан сонгуулийн зарчимд нийцэхгүй зүйл алга
    E. Сонгуулийн тэгш эрхийн зарчимд нийцэхгүй байна
58. Хэрвээ иргэдийн олонхи нь "улс төрийн лидер хүн гэдэг өрхийн тэргүүлэгчтэй ижил учир бид түүнийг үг дуугүй дагах ёстой" гэж үзэж байвал: (2 оноо)
    A. Ардчилсан үнэт зүйлс төлөвшөөгүйн шинж
    B. Ардчилсан бус үнэт зүйлс төлөвшиж чадаагүйн шинж
    C. Улс төрийн соёл төлөвшсөний шинж
    D. Сөрөг соёл давамгайлсаны шинж
    E. B ба D хувилбар

## ХОЁРДУГААР ХЭСЭГ

2.1. Доорх үзэл баримтлалууд аль намд харьяалагдаж болохыг олж холбоно уу. (5 оноо)
    A. Иргэдийг гарал үүслээр нь зэрэглэнэ.
    B. Нийгмийн асуудалд зарцуулах хөрөнгийн хэмжээг нэмнэ.
    C. Эдийн засагт төрийн оролцоо хамгийн бага байна.
    D. Төрийн өмч ноёрхох боловч хувийн өмч байна.
    E. Иргэдийн тэгш бус байдлыг хүчээр арилгана.
    1. Либерал 2. Социалист 3. Коммунист 4. Социал демократ 5. Фашист
2.2. Доор өгөгдсөн Монгол улсын гадаад улс төрийн бодлогын үндсэн чиглэлүүд болон гадаад харилцааны үйл ажиллагааг зөв тохируулна уу. (5 оноо)
    A. Социалист хамтын нөхөрлөлийн гэгдэж байсан орнууд, шинээр тусгаар тогтносон улсуудтай найрсаг харилцаа хөгжүүлэх
    B. Өрнө дорнын өндөр хөгжилтэй гүрнүүдтэй найрсаг харилцаа хөгжүүлэх
    C. Азийн бүс нутагт байр сууриа бататгаж, эндхийн улс төр, эдийн засгийн интеграцид оновчтой оролцох
    D. НҮБ болон түүний төрөлжсөн байгууллагууд ба Олон улсын санхүү эдийн засгийн байгууллагуудтай хамтран ажиллах
    E. ОХУ, БНХАУ-тай найрсаг харилцаатай байх

59. “Улаанбаатрын тунхаглал” гаргасан
60. Азийн хамтран ажиллах, итгэлцлийг бэхжүүлэх асуудлаарх зөвлөлгөөний гишүүн орон болсон
61. Мянганы сорилын санд хамрагдсан
62. Казахстан улсад Элчин сайдын яам байгуулсан
63. Азийн хөгжлийн банкнаас 3,3 сая ам. долларын буцалтгүй тусламжийн өртөг бүхий төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлсэн

## ХУВИЛБАР C

## НЭГДҮГЭЭР ХЭСЭГ

1. Пүүсийн (аж ахуйн нэгжийн) гол зорилго юу вэ? (1 оноо)
   A. Эх орноо шаардагдаж буй бүтээгдэхүүнээр хангах
   B. Аж ахуй эрхлэх чадвараараа бусадтай өрсөлдөх
   C. Ажилчдынхаа нийгмийн асуудлыг шийдэх
   D. Хөгжилд хувь нэмрээ оруулах
   E. Ашиг олох
2. Монгол улсын Үндсэн хуульд эдийн засгийн талаар заасан зөв заалтыг тэмдэглэнэ үү. (1 оноо)
   A. Олон хэвшил бүхий эдийн засагтай байна
   B. Төрийн өмч давамгайлсан эдийн засагтай байна
   C. Хувийн өмч давамгайлсан эдийн засагтай байна
   D. Зах зээлийн өрсөлдөөн бүхий эдийн засагтай байна
   E. Төрийн зохицуулалт бүхий эдийн засагтай байна
3. Ардчилсан төрийн эдийн засгийн үүргийг тоочихдоо үл хамаарах зүйл оруулсан бол сонгоно уу. (1 оноо)
   A. Зах зээлийн үйл ажиллагааны эрх зүйн үндсийг бүрдүүлэх
   B. Зах зээлийн үйл ажиллагааны аж ахуйн нэгжүүдийн үнэд нөлөөлөх
   C. Өрсөлдөөнийг хамгаалах
   D. Орлогыг дахин хуваарилах
   E. Эдийн засгийн тогтвортой байдлыг хангах
4. Аль нь макро эдийн засгийн судалгаа вэ? (1 оноо)
   A. Монголын ДНБ-ий өсөлт
   B. Японы зах зээлийн судалгаа
   C. Солонгосын автомашины үнэ
   D. Америкийн жижиг үйлдвэрлэлийн судалгаа
   E. Дээрх бүгд
5. Зах зээлийн үнэ гэдэг нь: (2 оноо)
   A. Эрэлт нь нийлүүлэлтээс бага байх үеийн үнэ
   B. Эрэлт нь нийлүүлэлтээс их байх үеийн үнэ
   C. Эрэлт нь нийлүүлэлттэй тэнцүү байх үеийн үнэ
   D. Худалдан авагч бүтээгдэхүүн үйлчилгээ авсаны төлөө худалдагчид төлж буй мөнгөн төлөөс
   E. Төрийн зүгээс бүтээгдэхүүн үйлчилгээнд тогтоож буй үнэ
6. Хэрвээ А барааны нийлүүлэлт X хэмжээтэй байхад эрэлт нь X+У байвал эдийн засгийн ямар үзэгдэл үүсэх вэ? (2 оноо)
   A. Үйлдвэрлэлийн хэмжээ буурах
   B. Эрэлт буурах
   C. Тэнцвэрт үнэ тогтох
   D. Барааны хомсдол үүсэх
   E. Түүхий эдийн хомсдол үүсэх
7. Аль нь төлбөрийн тухай тодорхойлолт вэ? (2 оноо)
   A. Үйлчилгээ үзүүлсний төлөө төсөвт эсвэл тусгай санд төвлөрүүлж буй мөнгөн хөрөнгө
   B. Тогтоогдсон хувь хэмжээгээр улс орон нутгийн төсөвт оруулж буй мөнгөн хөрөнгө
   C. Өмч ашиглуулсны төлөө төсөвт эсвэл тусгай санд төвлөрүүлж байгаа мөнгөн хөрөнгө
   D. Ажилчдын цалин хөлснөөс суутгаж байгаа татвар
   E. Дээрх бүгд
8. Хэрвээ ҮНБ - үндэсний нийт бүтээгдэхүүн, ҮЦБ - үндэсний цэвэр бүтээгдэхүүн, ҮО - үндэсний орлого, КЭ - капиталын элэгдэл, ГЦ - гадаад цэвэр гаргалт бол Үндэсний цэвэр бүтээгдэхүүний томьёог ол. (2 оноо)
   A. ҮЦБ=ҮНБ+ҮО
   B. ҮЦБ=ҮО+КЭ
   C. ҮЦБ=ҮНБ+ГЦ
   D. ҮЦБ=ҮНБ-КЭ
   E. ҮЦБ=ГЦ-ҮНБ

9. АНУ, ХБНГУ, БНСУ зэрэг улс орнуудад иргэдээ гаргаж, үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэх боломжийг төрөөс дэмжиж байгаа бол ажилгүйдлийг бууруулах ямар арга замд хамаарагдах вэ? (2 оноо)
   A. Эдийн засгийн арга
   B. Гадаад хүчин зүйлийг ашиглах арга
   C. Улс төрийн арга
   D. Захиргааны арга
   E. Соёлын нөлөөллийн арга
10. Инфляци өсөх хандлагатай байсан ба иргэд дараах үйлдлүүдийг хийсэн гэвэл аль нь илүү оновчтой шийдвэр вэ? (2 оноо)
   A. Орон сууцаа худалдсан
   B. Мөнгөөрөө орон сууц худалдаж авсан
   C. Орон сууцаа машинаар сольсон
   D. Мөнгөө банкинд хадгалуулсан
   E. Мөнгөө гэртээ хадгалсан
11. Бодит ҮНБ-ий үзүүлэлт ба нэрлэсэн ҮНБ-ий үзүүлэлтийн хоорондын харьцаа ямар байж болох вэ? (2 оноо)
   A. Бодит ҮНБ-ий хэмжээ нь их байна
   B. Нэрлэсэн ҮНБ-ий хэмжээ нь их байна
   C. Бодит ҮНБ нь нэрлэсэн ҮНБ-тэй тэнцүү үзүүлэлттэй байна
   D. Төсвийн хуулиар зохицуулагдана
   E. Аль нэг нь их эсвэл бага байж болно
12. Эдийн засгийн тогтолцоог уламжлалт, зах зээлийн, төлөвлөгөөт, холимог гэж ангилан судалж байгаа нь ШУ-ны танин мэдэхүйн ямар аргыг хэрэглэж байна вэ? (2 оноо)
   A. Анализ
   B. Синтез
   C. Индукци
   D. Дедукци
   E. Ажиглалт
13. ........................... гэдэг бол нийгэмд гүйцэтгэх үүргийг нь төрөөс хуулиар тогтоож өгсөн байдаг гэж үздэг нийгмийн давхраажлын үндсэн хэв маягийг юу гэж нэрлэдэг вэ? (1 оноо)
   A. Боолчлол
   B. Анги
   C. Каст
   D. Ялгарал
   E. Язгуур
14. Америкийн нийгэмд "хөх цамцтангууд" гэж ямар ангийг нэрлэдэг вэ? (1 оноо)
   A. Дээд анги
   B. Дунд анги
   C. Ажилчин анги
   D. Доод анги
   E. Хотод оршин суугчид
15. Нийгмийн давхраажилтын шатаар хүмүүс дээш, доош юм уу хэвтээ чиглэлээр шилжих үйл явцыг хэрхэн тодорхойлдог вэ? (1 оноо)
   A. Нийгмийн ялгарал
   B. Нийгмийн хөдөлмөрийн хуваарь
   C. Нийгмийн шилжих (мобиль) хөдөлгөөн
   D. Хүн амын шилжилт
   E. Хүн амын нягтшил
16. Нийгмийн хамгаалал хэнд чиглэгдэж байх ёстой вэ? (1 оноо)
   A. Эмзэг хэсгийнхэнд
   B. Ажилгүйчүүдэд
   C. Нийгмийн элит хэсгийнхэнд
   D. Нийгмийн бүх гишүүдэд
   E. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд
17. Нийгмийн даатгалын төрөлд үл хамаарагдах зүйл аль нь вэ? (1 оноо)
   A. Ажилгүйдлийн
   B. Тэтгэврийн
   C. Үйлдвэрийн ослын
   D. Хөрөнгийн
   E. Эрүүл мэнд
18. Нийгмийн давхраажилтын үндсэн хэв маягуудыг нэрлэ. (2 оноо)
   A. Боолчлол, каст, язгуур, анги
   B. Төр, улс төрийн нам, сонирхлын бүлэг
   C. Нэр хүнд, эд баялаг, эрх мэдэл, боловсрол
   D. Нэр төр, албан тушаал, ашгийн байдал
   E. Доод анги, дээд анги
19. Социализмийн үеийн Монголын анги давхрааны бүтцийн зөв загварыг олно уу. (2 оноо)
   A. Ажилчин, малчин, сэхээтэн
   B. Тариачин. албан хаагч, ажилчин
   C. Дарга, ажилчин, малчин
   D. Албан хаагч, үйлдвэрлэгч, худалдагч
   E. Дээд анги, дунд анги, доод анги
20. Нийгмийн шилжих хөдөлгөөн босоо ба хэвтээ чиглэлтэй байдаг. Эдгээрийн аль нь нийгмийн хэвтээ чиглэлийн шилжих хөдөлгөөний жишээ вэ? (2 оноо)
   A. Иргэн Болд манаач, сахиул, жижүүр зэрэг ажлуудыг хийж байв.
   B. Компанийн захирал Бат богино хугацаанд дампуурч ядуурав.
   C. Үйлчилгээний ажилтан Чимгээ өөрийн бизнесдээ амжилт олж, улмаар менежер болов.
   D. Малчин Дондог хязгаар нутгаас төвийн бүсэд шилжин суурьшив.
   E. Иргэн Зориг өндөр хөгжилтэй оронд цагаачлав.
21. Тухайн хүн хүүхэд үрчилж авсаныхаа төлөө нийгмийн халамжаас 49500 төг авсан байна. Үүнийг нийгмийн халамжийн тухай хуулинд хэрхэн тодорхойлсон байдаг вэ? (2 оноо)

A. Хүүхэд үрчлэн авч өсгөсний тэтгэлэг
B. Хүүхэд үрчлэн авч өсгөсний тэтгэвэр
C. Хүүхэд үрчлэн авч өсгөсний тэтгэмж
D. Хүүхэд асарсны тэтгэлэг
E. Ийм заалт байхгүй

22. Дараах субьектүүдээс хэн нь нийгмийн асрамжийн үйлчилгээ хүртэх эрхтэй вэ? (2 оноо)
A. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд
B. Нэн ядуу өрх
C. Бие дааж амьдрах чадваргүй, төрөл садангүй өндөр настан
D. 0-1 насны хүүхдээ асарч буй эх/эцэг
E. Дээрх бүгд

23. Аль бодомж нь зөв бэ? (1 оноо)
A. Хэм хэмжээ нь улс орон бүрт адил байна
B. Хэм хэмжээ нь улс орон бүрт өөр өөр байна
C. Хэм хэмжээ нь улс орон бүрт тогтмол байна
D. Хэм хэмжээ нь улс орон бүрт давтагдаж байна
E. Зөв бодомж алга. Дээрх бүгд буруу

24. Монголчууд түүхийн явцдаа уйгуржин, дөрвөлжин бичиг, латин, кирилл зэрэг бичгүүдийг хэрэглэж ирсэн билээ. Энэ нь соёлын ямар шинжид хамаарах вэ? (1 оноо)
A. Соёлын тогтонгид
B. Соёлын өөрчлөлтөнд
C. Соёлын тогтонги ба өөрчлөлтөнд
D. Соёлын өсөлтөнд
E. Соёлын бууралтанд

25. Хүн амын аль нэг бүлэг даган баримталдаг соёлыг онолын нэрээр хэрхэн тодорхойлдог вэ? (1 оноо)
A. Явцуу соёл
B. Бага соёл
C. Ардын соёл
D. Нийтийн соёл
E. Сөрөг соёл

26. П.Пикассогийн “Амьдралын баясгалан” зураг соёлын ямар хэлбэрт хамаарагдах вэ? (1 оноо)
A. Өрнөдийн соёл
B. Дорнын соёл
C. Элитийн соёл
D. Ардын соёл
E. Нийтийн соёл

27. Нийгмийн туршлагыг хуримтлуулж, цааш дамжуулж байдаг нь соёлын .................................... юм. (2 оноо)
A. Харилцааны үүрэг
B. Хэм хэмжээ тогтоох үүрэг
C. Танин мэдүүлэх үүрэг
D. Мэдээллийн үүрэг
E. Албан ёсны үүрэг

28. 1930-аад оны үед 700 гаруй буддын сүм хийдийг нураан сүйтгэсэн нь ямар шалтгаантай вэ? (2 оноо)
A. Буддын шашин нь нийгэмд сөрөг үр дагавар авчирж байсан учир
B. Лам нар олноор хар болсон учир
C. Буддын шашин нь хямралд орсон учир
D. Буддын шашин нь монголын соёлтой нийцэхгүй байсан учир
E. Төрөөс шашинг сөрөг соёл гэж үзсэн учир

29. Эртний Грек, Ромын үеийн нийгмийн зохион байгуулалтын салбар дахь соёлын ололт юу вэ? (2 оноо)
A. Театр, риторик, цирк, чимэглэл, баримал туульс
B. Шинжлэх ухааны үүсэл, хүмүүжлийн тогтолцоо
C. Олимпийн наадам, он тоолол
D. Римийн эрх зүй, хот - улс, ардчилсан БНУ
E. Гүн ухааны сургаал

30. Улс төрийн соёлын тухай ойлголтонд аль нь хамааралтай вэ? (2 оноо)
A. Улс төрд оролцогчдын биеэ авч явах соёл
B. Биологи хүчин зүйлүүдийн нэгдэл
C. Улс төрийн үйл ажиллагаанд оролцогчдын итгэл үнэмшил
D. Нийтийн соёлын хэмжээ
E. Нийцтэй улс төрийн оролцоо

31. Олон улсын харилцааны хүмүүнлэгийн салбарт хамаарагдахгүй чиглэлийг дурьдсан бол аль нь вэ? (1 оноо)
A. Эмэгтэйчүүд, хүүхдийн эрхийг хамгаалах
B. Химийн болон бактерологийн зэвсэг дэлгэрүүлэхгүй байх
C. Ядуурал, гуйланчлал, өлсгөлөнг арилгах
D. Хүний эрхийг хамгаалах
E. Бүгд хамаарагдана

32. Монгол улсын гадаад харилцааны олон тулгуурт зарчим гэдэг нь: (1 оноо)
A. Идэвхитэй гадаад бодлого явуулах
B. Тэнцвэртэй гадаад бодлого явуулах
C. Үндэсний эрх ашигт нийцсэн бодлого явуулах
D. Тооны олон, хэлбэрийн олон харилцаа явуулах
E. Тооны олон, хэлбэрийн цөөн харилцаа явуулах

33. Ямар улсын санаачлагаар Монголд хандивлагч улсуудын зөвлөлгөөн анх зохион байгуулагдсан бэ? (1 оноо)
    A. Герман  B. Япон  C. БНСУ  D. АНУ  E. Монгол
34. НҮБ-ын төрөлжсөн байгууллагад орохгүй байгууллагыг олно уу. (2 оноо)
    A. Олон улсын валютын сан
    B. Дэлхийн эрүүл мэндийн байгууллага
    C. Дэлхийн оюуны өмчийн байгууллага
    D. Олон улсын шүүх
    E. Дэлхийн цаг уурын байгууллага
35. Эвсэлд үл нэгдэх зарчмыг мөрдөх нь ямар ач холбогдолтой вэ? (2 оноо)
    A. Даяаршлийн сөрөг нөлөөллөөс сэргийлэх
    B. Улс орондоо гадны цэрэг оруулахгүй байх
    C. Үүрэг хариуцлага хүлээхгүй байх
    D. Бусдаас ялгарахгүй байх
    E. Дайны аюулаас сэргийлэх
36. Яагаад 1955 онд Варшавын гэрээний орнуудын байгууллага хэмээх эвсэл байгуулагдсан бэ? (2 оноо)
    A. Социалист орнуудын гадаад бодлогыг төвлөрүүлэх үүднээс
    B. Дэлхий дээр олон туйлт харилцаа тогтоохын тулд
    C. НАТО-ийн эсрэг сөрөн зогсохын тулд
    D. НАТО-тай хамтран ажиллахын тулд
    E. Дэлхийд энх тайван тогтоохын тулд
37. УИХ-аас соёрхон баталсан Олон улсын конвенци нь дотоодын хууль тогтоомжтой зөрчилдөж байгаа бол: (2 оноо)
    A. Уг конвенци хүчингүй болно
    B. Уг конвенцийг дотоодын хууль тогтоомжид тохируулан өөрчилнө
    C. Үндсэн хуулийн цэцээр хэлэлцэгдэнэ
    D. УИХ-аар дахин хэлэлцэнэ
    E. Дотоодын хууль тогтоомжийг уг конвенцид нийцүүлэн өөрчилнө
38. Монгол улсын элсэн ороогүй Олон улсын байгууллагыг олно уу. (2 оноо)
    A. Европын сэргээн босголт, хөгжлийн банк
    B. Азийн хамтран ажиллах, итгэлцлийг бэхжүүлэх асуудлаарх зөвлөлгөөн
    C. Азийн хөгжлийн банк
    D. Дэлхийн худалдааны байгууллага
    E. Тийм хариулт алга
39. “Чи миний төлөө юм хийнэ, яагаад гэвэл чи намайг хүндэлдэг “ гэж хэлэх нь эрх мэдлийн ямар хэлбэр вэ?
    A. Хүч хэрэглэх эрх мэдэл
    B. Үүрэг үүсгэх эрх мэдэл
    C. Наймаалцах эрх мэдэл
    D. Хүндлүүлэх эрх мэдэл
    E. Итгүүлэх эрх мэдэл
40. Ардчиллын бус үнэт зүйлийг нэрлэнэ үү. (1 оноо)
    A. Хүний эрх
    B. Шударга сонгууль
    C. Эрх мэдлийн төвлөрөл
    D. Нээлттэй байдал
    E. Хуульд захирагдах ёс
41. Улс төрийн системийн сонирхлыг нэгтгэх үйл ажиллагааг аль нь голлон гүйцэтгэдэг вэ? (1 оноо)
    A. Улс төрийн нам
    B. Сонирхлын бүлгүүд
    C. Төр
    D. Иргэд
    E. Дээрх бүгд
42. “Улс төр бол аливаа хувьсгалт намын практик үйл ажиллагааны эхлэх цэг бөгөөд тэрхүү үйлдэл ажиллагааны явц ба эцсийн үр дүнгээр илэрдэг.” гэсэн тодорхойлолтыг дүгнэж үзвэл ямар шинж чанарыг агуулсан байна вэ? (2 оноо)
    A. Улс төрийг ёс зүйн үүднээс тодорхойлсон
    B. Улс төрийг практик талаас нь тодорхойлсон
    C. Улс төрийг зүүний үзэл баримтлалын өнцгөөс тодорхойлсон
    D. Улс төрийг барууны үзэл баримтлалын талаас тодорхойлсон
    E. Улс төрийг институтийн онолоор тодорхойлсон
43. Засгийн газрын ...-р тогтоолыг ҮЭ-ээс эсэргүүцэж шаардлага тавьсны дагуу Засгийн газрын зүгээс уг тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулжээ. Энэ үйл явц нь улс төрийн системийн аль бүтцэд хамаарах вэ? (2 оноо)
    A. Улс төрийн системийн эргэх холбоо
    B. Улс төрийн системийн оролт
    C. Улс терийн системийн гаралт
    D. Улс төрийн системийн орчин
    E. Дээрх хариултуудын аль нь ч биш

44. Эх сурвалж. Луков - Данненбергийн иргэдийн санаачилсан ухуулах хуудас. Германд атомын аж үйлдвэрийн байгууламжийн эсрэг, ерөөс нутгаа хэт барилгажуулахын эсрэг шууд хүч хэрэглэхгүй суулт хийх, хэвтэж хаалт болох зэргээр эсэргүүцэл гаргадаг. Энэ бүхэн нь бүх хүний амьдралын төлөө учир цагдаагийн оролцоо хэрэггүй... Парламентын олонхи ч энэ хариуцлагыг бидэнд олгоогүй юм. Бидний энэ арга хэмжээ бол Үндсэн хуулиар олгогдсон эсэргүүцэх эрхээ л ашиглаж байгаа хэрэг мөн.
Дээрх эх сурвалж нь улс төрийн системийн аль бүрэлдэхүүн хэсгийн тухай өгүүлж байна вэ? (2 оноо)
    A. Улс төрийн системийн орчин
    B. Улс төрийн системийн оролт
    C. Улс төрийн системийн гаралт
    D. Улс төрийн системийн эргэх холбоо
    E. Улс төрийн системийн шийдвэр
45. Хэрвээ улс төрийн нам байгаль орчныг хамгаалах талаарх төрийн бодлогыг эсэргүүцсэн иргэдийн хөдөлгөөнийг дэмжиж байвал энэ нь ямар төрлийн улс төрийн нам бэ? (2 оноо)
    A. Консерватив нам
    B. Ардчилсан нам
    C. Зүүн төвийн нам
    D. Либерал нам
    E. Аль нь ч байж болно
46. Хэсэг аж ахуй эрхлэгчид татварын шинэ хуулийг эсэргүүцэж нэг удаагийн жагсаал хийжээ. Эдгээр хүмүүс нь сонирхлын бүлгийн аль хэв шинжид хамаарах вэ? (2 оноо)
    A. Холбооны шинжтэй
    B. Бүрдлийн шинжтэй
    C. Холбооны бус шинжтэй
    D. Тодорхойгүй төлөвтэй
    E. Нийгмийн шинжтэй
47. Ардчиллын сонгодог онол ба олон ургальч ардчиллын онолууд нь ямар асуудлаар хоорондоо өөр байр суурьтай байдаг вэ? (2 оноо)
    A. Ардчилсан засаглал нь хэнээс эхтэй байх вэ гэсэн асуудлаар
    B. Төр засаг нь хэний өмнө хариуцлага хүлээх вэ гэсэн асуудлаар
    C. Сонгуулийн ямар системийг хэрэглэх асуудлаар
    D. Улс төрийн ямар нам ноёрхох ёстой вэ гэсэн асуудлаар
    E. Тийм асуудал байхгүй
48. 1990 онд Монгол улсад ардчилсан хувьсгал гарахад аль хүчин зүйл нөлөөлсөн бэ? (2 оноо)
    A. Нэг намын тогтолцоо
    B. Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн үр ашиггүй байдал
    C. Үзэл суртлын дарангуйлал
    D. ЗСБНХУ-ын задрал
    E. Дээрх бүх хүчин зүйлс нөлөөлсөн
49. Хэрвээ иргэдийн олонхи нь "хүмүүс үзэл бодлоороо хуваагдах нь нийгэмд эмх замбараагүй байдал бий болгох аюултай" гэж үзэж байвал: (2 оноо)
    A. Улс төрийн соёл төлөвшсөний шинж
    B. Ардчилсан бус улсын шинж
    C. Ардчилсан үнэт зүйлс төлөвшөөгүйн шинж
    D. Сөрөг соёл давамгайлсаны шинж
    E. B ба D хувилбар
50. Аль бодомж нь зөв бэ? (1 оноо)
    A. Нийгэмшил нь хүүхэд эхийн хэвлийд олдсон үеэс эхлэл нь тавигддаг.
    B. Нийгэмшил нь нярай үеэс эхлэл нь тавигддаг
    C. Нийгэмшил нь хүүхэд хэлд орсноор эхлэл нь тавигддаг
    D. Нийгэмшил нь идэр наснаас эхлэл нь тавигддаг
    E. Нийгэмшил нь ахмад үеэс эхлэл нь тавигддаг
51. Аль нь нийгэмшлийн хүчин зүйлүүдэд шууд хамааргдахгүй вэ? (1 оноо)
    A. Боловсролын түвшин
    B. Хэлний мэдлэг
    C. Гэр бүлийн орчин
    D. Хамт олны хүрээлэл
    E. Нутаг дэвсгэрийн хэмжээ
52. 1990 оноос Монголын нийгмийн харилцаанд эрс шинэчлэлт хийгдэн, хүмүүсийн амьдрах аргад томоохон өөрчлөлт гарч байгаа нь: (1 оноо)
    A. Нийгмийн дэвшил
    B. Нийгмийн шинэтгэл
    C. Нийгмийн шинэчлэл
    D. Нийгмийн хувьсал
    E. Нийгмийн хувьсгал
53. Сурагч Бат өндөр нуруутай, хар үстэй бөгөөд сагсан бөмбөг сайн тоглодог. Батын эдгээр шинж нь ямар ойлголтонд хамаарагдах вэ? (1 оноо)
    A. Бие хүн
    B. Хувь хүн
    C. Суут хүн
    D. Авьяастай сурагч
    E. Онцгой хүн

54. “Ургийн бичиг” хөтлөхийн гол ач холбогдол нь: (1 оноо)
    A. Хүн өөрийн овог удмаа мэддэг болох
    B. Бичиг баримт хөтөлж сурах
    C. Нэр хүндээ дээшлүүлэх
    D. Эд баялаг, өмч хөрөнгөтэй болох
    E. Иргэний үнэмлэх авах
55. Иргэний нийгмийн тухай сонгодог ойлголтыг ямар сэтгэгчид дэвшүүлэн тавьсан бэ? (1 оноо)
    A. Маркс, Энгельс
    B. И.Кант, Гегель
    C. Аристотель, Платон
    D. Агваанбалдан, Агваанхайдав
    E. Монтескье, Декарт
56. Сонирхлын бүлэгт хамаарах нь аль вэ? (1 оноо)
    A. Иргэний нийгмийн хэлбэр мөн
    B. Иргэний нийгмийн хэлбэр биш
    C. Тухайн нөхцөл байдлаас хамаарна
    D. Дарангуйлагчийн эсрэг хөдөлгөөн
    E. C ба D хариулт
57. Монгол улсын Үндсэн хуулинд “..... хуулиар ноогдуулсан албан татвар төлөх үүрэгтэй” гэж заасан байдаг нь Монгол улсын иргэний: ............................. юм. (2 оноо)
    A. Журамт үүрэг
    B. Үндсэн үүрэг
    C. Үндсэн эрх
    D. Иргэний эрх
    E. Ийм заалт байхгүй
58. Аж үйлдвэржсэн ба аж үйлдвэржсэний дараах нийгмийн үндсэн ялгааг олно уу. (2 оноо)
    A. Оршин тогтнож буй цаг хугацаа
    B. Тухайн нийгмийн хамарсан хүрээ
    C. Хөгжлийн үндэс
    D. Ноёрхогч нийгмийн бүлэг
    D. Хүн амын тоо, нягтшил

## ХОЁРДУГААР ХЭСЭГ

2.1. Доорх үзэл баримтлалууд аль намд харьяалагдах болохыг зөв холбоно уу. (5 оноо)
    A. Эдийн засагт төрийн оролцоо хязгаарлагдмал байна
    B. Хувийн өмчтөний үйлдвэрлэсэн нийгмийн баялгийн хуваарилалтанд төрөөс хяналт тавина
    C. Улс орны бодлогын гол цөм нь үндсэрхэг үзэл байна
    D. Эдийн засагт төрийн оролцоо давамгайлах чиглэлийг баримтална
    E. Хувийн өмчийг хурааж төрийн өмч болгоно
    1. Социал демократ  2. Коммунист  3. Социалист  4. Либерал  5. Фашист
2.2. Дараах ойлголтуудыг зөв холбоно уу. (5 оноо)
    A. Нийгэм дэх зохицуулагч хэм хэмжээ, зан заншлуудын цогц
    B. Нийгэмд хамаарахуйц эерэг үр дагаврууд
    C. Нийгэмд хэсэгчилсэн болон аажим хувьсал хийх
    D. Нийгмийн хуучин байгуулал шинэ байгуулалд эрс шилжилт хийх үйл явц
    E. Нийгмийн амьдралын бүх хүрээг хамарсан иж бүрэн суурь өөрчлөлт
    1. Хувьсгал  2. Шинэчлэл  3. Шинэтгэл  4. Дэвшил  5. Соёл

# 2006 оны Нийгмийн тухай мэдлэг хичээлийн даалгаврын түлхүүр

| Нэгдүгээр хэсэг | | | |
|---|---|---|---|
| № | Хувилбар A | Хувилбар B | Хувилбар C |
| 1 | A | C | E |
| 2 | E | A | A |
| 3 | E | C | B |
| 4 | B | A | A |
| 5 | A | E | D |
| 6 | B | E | D |
| 7 | A | B | C |
| 8 | B | C | D |
| 9 | C | B | B |
| 10 | B | A | B |
| 11 | B | A | E |
| 12 | B | D | A |
| 13 | C | A | E |
| 14 | E | A | C |
| 15 | D | B | C |
| 16 | D | A | D |
| 17 | C | A | D |
| 18 | E | E | A |
| 19 | C | E | A |
| 20 | C | C | A |
| 21 | D | C | C |
| 22 | D | D | E |
| 23 | A | E | B |
| 24 | A | A | B |
| 25 | C | D | B |
| 26 | E | B | C |
| 27 | A | A | D |
| 28 | E | D | E |
| 29 | A | C | D |
| 30 | A | E | C |
| 31 | B | C | B |
| 32 | D | B | D |
| 33 | D | C | B |
| 34 | C | D | D |
| 35 | D | C | E |
| 36 | B | D | C |
| 37 | B | B | E |
| 38 | E | C | E |
| 39 | A | B | B |
| 40 | B | B | C |
| 41 | A | C | A |

| № | Хувилбар A | Хувилбар B | Хувилбар C |
|---|---|---|---|
| 42 | C | C | C |
| 43 | C | B | A |
| 44 | A | B | B |
| 45 | B | E | E |
| 46 | E | A | D |
| 47 | D | A | B |
| 48 | B | E | E |
| 49 | E | C | C |
| 50 | C | E | A |
| 51 | B | C | E |
| 52 | D | D | E |
| 53 | B | D | B |
| 54 | D | D | A |
| 55 | E | E | B |
| 56 | C | C | A |
| 57 | E | E | B |
| 58 | E | A | C |

| Хоёрдугаар хэсэг | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | Хувилбар A | | Хувилбар B | | Хувилбар C | |
| | 2.1 | 2.2 | 2.1 | 2.2 | 2.1 | 2.2 |
| a | 4 | 3 | 5 | 4 | 4 | 5 |
| b | 2 | 1 | 4 | 3 | 3 | 4 |
| c | 3 | 5 | 1 | 2 | 5 | 3 |
| d | 5 | 4 | 2 | 5 | 1 | 1 |
| e | 1 | 2 | 3 | 1 | 2 | 2 |